



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 356

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан нийт 10,445,011,233.7 (арван тэрбум дөрвөн зуун дөчин таван сая арван нэгэн мянга хоёр зуун гучин гурван төгрөг далан мөнгө) төгрөгийн үнэ бүхий дэд бүтцийн барилга, байгууламжийг тус яамны дуусаагүй барилгын данснаас хасаж, хавсралтад заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ш.Үнэнбат, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Нохойжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримтыг үндэслэн хүлээлцэх ажлыг зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
2019 оны 08 сарын 29- ний өдрийн
3.56. дугаар тогтоолын хавсралт

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ЗАХИАЛГААР
УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН,
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Барилга, байгууламж (хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ)-ийн нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Хүлээн авч ашиглах, үндсэн хөрөнгөд бүртгэх хуулийн этгээдийн нэр
1	Улаанбаатар хот, Баянголын амны орон сууцны хорооллын 10 ширхэг ус, дулаан дамжуулах төвийн барилга, дагалдах дэд бүтцийн байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил	139,973,132.0	"Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ (нийслэлийн өмчит)
2	Улаанбаатар хот, Яармагийн орон сууцны хорооллын 14.5 бохир усны шугам, насос станцын барилга зураг төсөл, барилга угсралтын ажил	230,038,537.0	Ус сувгийн удирдах газар (нийслэлийн өмчит)
3	Улаанбаатар хот, Яармагийн орон сууцны хорооллын гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажил		"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компани
4	Улаанбаатар хот, Ирээдүй цогцолбор хорооллын 2 дугаар ээлжийн 2*630 кВа чадалтай ТП- 1 иж бүрдэл, 5 км урт 10 кВ-ын шугам, дагалдах хөрөнгө	323,876,675.0	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компани
5	Улаанбаатар хот, Буянт-Ухаа орон сууцны хорооллын 20000 м.куб бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил	8,999,983,085.0	Ус сувгийн удирдах газар (нийслэлийн өмчит)
6	Улаанбаатар хот, Буянт-Ухаа орон сууцны хорооллын 20000 м.куб бохир ус цэвэрлэх байгууламжийн гадна дулаан хангамжийн өөр эх үүсвэртэй болгох зураг төсөл, барилга угсралтын ажил	399,445,242.0	Ус сувгийн удирдах газар (нийслэлийн өмчит)
7	Ховд аймгийн төвийн 4200 м.куб хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил	132,351,562.0	Шим ус ОНӨААТҮГ

8	Улаанбаатар хот, VII хорооллын 12 хэсгийн 6 ширхэг ус, дулаан дамжуулах төвийн барилга, гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажил	219,343,000.0	"Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ (нийслэлийн өмчит)
	Нийт дүн	10,445,011,233.00	
		(арван тэрбум дөрвөн зуун дөчин таван сая арван нэгэн мянга хоёр зуун гучин гурван)	